



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/07

Сүхбаатар сум

Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Төсвийн тухай хуулийн 30.1.1, Улсын Их хурлын 2009 оны "Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт төр хувийн хэвшлийн итгэлцлийг бэхжүүлэх, бизнес хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, жижиг дунд бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа саад бэрхшээлийг арилгахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, худалдаа, татвар, бизнес эрхлэх зөвшөөрөл дүрэм, журмыг сайжруулах саналыг төрийн бус байгууллагын оролцоотой боловсруулж, төрийн бодлогод тусган хэрэгжилтийг хангах үүрэг бүхий "Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо"-ны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.


2. Зөвлөлдөх хорооны үйл ажиллагааны жил, улирлын төлөвлөгөөг боловсруулж, зөвлөлөөс гарсан санал зөвлөмжийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллахыг /Зөвлөлийн дарга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
07 дүгээр сарын 15-ны өдрийн  
А/07 дүгээр захирамжийн хавсралт



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ЗӨВЛӨЛДӨХ  
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

-Монголын үндэсний худалдаа аж  
үйлдвэрийн танхимын Сэлэнгэ салбарын дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга-

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга/

-Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын  
дарга

-Аймгийн Хоршоологчдын холбооны дарга

-Аймгийн Аялал жуулчлалын холбооны дарга

-Аймгийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн  
холбооны дарга

-Аймгийн Баялаг бүтээгчдийн холбооны дарга

-Аймгийн Иргэний нийгмийн холбооны дарга

-Аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга

-Аймгийн Ахуйн үйлчилгээний салбар

-Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн  
холбоо

\_\_\_ооо\_\_\_